



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот


Г Албан томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан томилолтоор ажиллуулах журам”-ын 2.1, 3.1, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газарт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 57 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, саналаа өгөх удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Албан томилолтын тайланг ажлын 5 өдөрт багтаан танилцуулахыг Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын алба /Ц.Шинэхүү/-д даалгасугай.

3.Албан хаагчийн томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.



132013644

ТӨБЗГ тушаал-/2023

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2023 оны 08 дугаар сарын 03.-ний өдрийн
4/62 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ОРХОН АЙМАГТ ТОМИЛОЛТООР
АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1. Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газарт дараах чиглэлээр асуудлыг судлан, санал, дүгнэлтэд саналаа өгөх.

Хоёр. Санал, дүгнэлт гаргах асуудлын чиглэл

2.1. “Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрлэлийн технологийн хаягдал булинга, элсний хуримтлалаас дэгддэг цагаан шороо, тоосноос байгаль орчин, иргэдийн эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилт, үр дүн;

2.2. Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэр дэх “Уул уурхай-металлурги-химиийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн ажлын явц, “Эрдэнэс YTP” ХХК байгуулсан Засгийн газрын 2023 оны 257 дугаар тогтоолын хэрэгжилт;

2.3. Хууль, хяналтын байгууллагад шалгагдаж байгаа Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийн энгийн хувьцааг худалдан авсан гэх хэрэг маргааны явц байдал, тулгамдаж буй асуудал;

2.4. Үйлдвэрлэлийн явцад үүссэн исэлдсэн хүдрийн болон тодорхой үр ашиггүй, ядуу агуулгатай хүдрийн овоолгын өнөөгийн нөхцөл, байдал, ашиглалт;

2.5. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилт.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 03.-ний өдрийн 4/62.. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газарт дараах чиглэлээр асуудлыг судлан, санал, дүгнэлтэд саналаа өгөх албан томилолтын зардлын төсөв.

Хугацаа: Ажлын хэсэг 08 дугаар сарын 03-ны өдрөөс 08 дугаар сарын 05-ны өдрүүдэд /хуанлийн 3 хоногоор/ хийж гүйцэтгэнэ.

Д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөгөөр/
1	2	3
1	Байр: 1 хүн x 3 хоног x 110,000 =330,000 Хоол: 1 хүн x 3 хоног x 32,000 = 96,000	426,000
	Нийт дүн:	426,000

Тайлбар: Дотоод томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаалаар баталсан “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” тушаалыг үндэслэв.